БАТЛАВ
ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА В. ХҮҮХЭНДҮҮ

ТӨРИЙН АЛБАНД ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХҮРЭЭНД “ШИНЭ МЯНГАН АЙЛ” ОРОН СУУЦЖУУЛАХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ 16 АЙЛЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ОРОН СУУЦ ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025.06.24 Цогтцэций

		Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
1	Ажлын даалгавар боловсруулах үндэслэл, зорилго	Орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс жил бүр тодорхой хөрөнгө гаргаж, түрээсийн орон сууцны барилга захиалж бариулах, эсхүл шинээр баригдаж, ашиглалтад орсон боловч зах зээл дээр борлогдоогүй орон сууцнаас худалдан авах замаар орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх;
2	Захиалагч байгууллага:	Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газар
3	Зориулалт	Орон нутагт төрийн үйлчилгээг сайжруулах төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг нэмэгдүүлэх
4	Хөрөнгийн эх үүсвэр	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 2,542,000,000 төгрөг
		Өмнөговь аймаг, Цогтцэций суманд байршилтай өөрийн
5	Байршил	эзэмшлийн газар дээр зураг, төсөл нь төлөвлөгдсөн, дуусаагүй, ашиглалтад орсон барилга, байгууламж байна.
6	Худалдан авах барилга, байгууламжийн хүчин чадал, хамрах хүрээ	Орон сууцны нэг айлын м.кв-ын хэмжээ 25-80 м.кв – н хооронд, 16 ба түүнээс дээш тооны орон сууцыг Цогтцэций суманд хүлээлгэн өгнө.
7	Барилга, байгууламжийн зураг, төсөл, баримт бичигт тавигдах шаардлага	- Эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан, зураг төслийг магадлалаар хянан баталгаажуулсан баримт бичгүүдийг ирүүлнэ; - Барилга, байгууламжийн төвөгшлийн зэрэгт тохирсон барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн гэрээ, холбогдох бичиг баримтуудыг ирүүлнэ; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан; - Орчны архитектур төлөвлөлттэй уялдуулан гадна засал, тагтны хашлага, хаалтыг төлөвлөсөн байна; - Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байна;

		- Гадна тохижилтыг хийхээр бүрэн тусгасан байна. - Барилга, байгууламжийн төсөвт өртгийн тооцоо бүрэн хийгдэж Монгол Улсын Мэргэшсэн төсөвчин, эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.
8	Барилга, байгууламжийг хүлээн авахад тавигдах шаардлага	- Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ, тусгай зөвшөөрөл, улсын бүртгэлийн гэрчилгээ ирүүлэх - Тухайн үл хөдлөх эд хөрөнгөд эрх бүхий байгууллагаас олгосон дугаар, байршлын хаягийн бүртгэлийг хийлгэж хүлээлгэн өгөх бөгөөд татгалзах зүйлгүй талаар албан бичиг /хаягжуулалт/ - Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссын дүгнэлт; /Эх хувиас скайнердсан/ - Барилга байгууламжийн иж бүрэн зураг, төсөл; - Барилгын гэрэл зураг /4 тал, нийтийн эзэмшил, шугам сүлжээ г.м/ - Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд тэмдэгтийн хураамж болох эд хөрөнгийн үнийн дүнгийн 0,01 хувиар тооцож төлөх бөгөөд төлөхөд татгалзах зүйлгүй талаар албан мэдэгдэл ирүүлнэ; - Барилгын доорх газрын эзэмшил, өмчлөлийн гэрчилгээ, гэрээ, кадастрын зургийг ирүүлэх бөгөөд эзэмшигч, өмчлөгч, иргэн хуулийн этгээдээс худалдан авагч талд шилжүүлэхэд татгалзах зүйлгүй талаар албан мэдэгдэл ирүүлнэ;
9	Орон сууц нийлүүлэх хугацаа	2025 оны IV дүгээр улирал;
10	Галын аюулгүй байдлын нөхцөл	“Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал” -БНбД 21.01.02 “Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм” –БНбД 21.01.02 болон галын аюулгүй байдлын бусад стандарт, норм, дүрмийн дагуу төлөвлөгдсөн барилга байгууламж байх (галын дохиолол, гал унтраах багаж, хэрэгсэл, галын аюултай бодис хадгалах агуулах, галын гидрант .....г.м)
11	Эдийн засгийн тооцоо	- Орон нутгийн орон сууцны зах зээл дэх 1м2-ын дундаж үнэлгээнээс ихгүй үнийн санал ирүүлсэн байх, өрсөлдөгч байгууллагын үнийн судалгаа гаргасан байх;
12	Онцгой нөхцөл	- Газар хөдлөлтийн 8 баллд тэсвэртэй, газар хөдлөлийн үеийн аюулгүй байдал нөхцөл шаардлагыг хангасан барилга, байгууламж; - Байгаль цаг уурын үзүүлэлтүүдэд тулгуурлан үер, бороо, үерийн усны хамгаалалт төлөвлөгдсөн; - Ажлын эзлэхүүнд тусгагдсан бусад шаардлагыг хангасан байна

БОЛОВСРУУЛСАН:

ХАА хариуцсан ажилтан Ц. Эрдэнэбаяр